

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 06 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Нэг. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны хүрээнд:

Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Ажлын албанаас 06 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн ИТХ-ын XIII, Тэргүүлэгчдийн VIII, Тэргүүлэгчдийн ээлжит бус IV, IX хуралдаан тус тус хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын XIII хуралдаанаар:

-Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тухай өргөн мэдүүлсэн тайлан, төсөл, тэдгээрт Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хороо, Төв аймаг дахь Төрийн Аудитын газраас хийсэн дүгнэлтүүдийг хэлэлцээд аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлээр төсвийн нийт орлогыг 18710.7 сая төгрөг, аймгийн төрийн сан дахь жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 8606.9 сая төгрөг, төсвийн зарлагын гүйцэтгэлийг 76128.2 сая төгрөгөөр батламжлав.

-“Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” тогтоолын зарим заалтад өөрчлөлт оруулах, жагсаалт батлах тухай, аймгийн 2019 оны худалдан авах ажиллагааны эхний 5 сарын гүйцэтгэл, зарим төсөв хооронд зохицуулалт хийх тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны Арваннэгдүгээр хуралдааны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолын 10 дугаар заалтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д өөрчлөлт оруулж “Тогтоолын зарим заалтад өөрчлөлт оруулах, жагсаалт батлах тухай” тогтоол батлав.

-Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн сум хоорондын хилийн цэсэд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг дэмжиж “Зуунмод, Сэргэлэн сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай”, “Сэргэлэн сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай” тогтоолуудыг батлан Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт уламжлав.

-Монгол наадам цогцолборын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрын хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 456 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээний газарт авсан “Монгол наадам цогцолбор”-ын газрын хэмжээ, хилийн цэсэд өөрчлөлт оруулах шийдвэрийн төсөл боловсруулсан тухай мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Монгол улсын Засгийн газрын 2015 оны 456 дугаар тогтоолоор “Монгол наадам цогцолбор”-ын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрын Төв аймгийн нутаг дэвсгэрт хамаарах хэсгийн газрын хэмжээ, хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналыг дэмжиж “Улсын тусгай хэрэгцээний газрын хэмжээ, хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай” тогтоолыг батлан Монгол Улсын Засгийн газарт уламжлав.

-Зарим газар нутгийг тусгай хэрэгцээ, хамгаалалтад авах тухай санал, мэдээлэл, түүнд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Заамар сумын зарим газар нутгийг аймгийн Тусгай хэрэгцээний газраас хэсэгчилэн чөлөөлж, бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах саналыг хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн 88.5 хувийн саналаар дэмжих боломжгүй гэж үзэв.

-Буддын шашны сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах тухай зарим иргэдийн хүсэлтийн талаарх мэдээлэл, өргөн мэдүүлсэн холбогдох баримт бичиг, төсөл, түүнд Хурлын Нутгийн удирдлага, хууль хяналт, гадаад харилцааны хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Төв аймгийн Батсүмбэр сумын Мандал I багийн нутаг дэвсгэрт “Даштэгчинлин” хийд, Дэлгэрхаан сумын II багийн нутаг дэвсгэрт “Норовчойнпэллин” хийд, Зуунмод сумын Баянхошуу III багийн нутаг дэвсгэрт “Дашнамдоллин” буддын шашны хийдэд тус тус шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхи дэмжиж хийдүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын нутгийн удирдлагын байгууллага болон хууль хяналтын байгууллагад үүрэг болголоо.

-“Төв аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулсан тухай мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Нутгийн удирдага, хууль хяналт, гадаад харилцааны хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд “Төв аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн “Төв аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлсний дараа мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн байдлыг хагас жил бүр шалган танилцаж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгаж тус тогтоол, журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албанд даалгалаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн VIII хуралдаанаар 15 асуудал хэлэлцэж 7 тогтоол, Хурлын байнгын хороодод дүгнэлт гаргуулахаар 8 асуудлыг шилжүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулахаар 1 асуудлыг шилжүүлж, нэг асуудлыг буцаав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус IV хуралдаанаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIII хуралдаанаар хэлэлцэх 7 асуудалд Хурлын хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Хурлын хуралдаанд шилжүүлж, төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцэн нийт 94 иргэнийг төрийн дээд одон медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн IX хуралдаанаар 7 асуудал хэлэлцэж 3 тогтоол батлан хуралдааны 3 тэмдэглэлээр үүрэг өгөв.

Энэ сард аймгийн ИТХ-ын дарга, ажлын албанд хандсан 22 албан бичиг ирснийг бүртгэн аймгийн ИТХ-ын дарга болон нарийн бичгийн даргад танилцуулан хариу өгөх

шаардлагатай 3 албан бичгээс 2 албан бичгийн хариуг өгч 1 албан бичгийг аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-т шилжүүлэв.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: 2019 оны 06 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж, 20 асуудлыг хэлэлцэн холбодох шийдвэрийг гарган ажилласан.

2019 оны 06 дугаар сарын 28-ны байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 61 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дээд шатны яам, агентлагт уламжилсан. Холбогдох яам, дээд шатны байгууллагаас дэмжсэн санал ирүүлсэн 152 иргэний тодорхойлолтыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.06.03, 2019.06.12, 2019.06.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 50 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 76 иргэнийг шагнаж, урамшууллаа.

“Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын 3.1.1, аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/718 захирамжаар баталсан хуваарийн дагуу “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга иргэдийн санал, хүсэлтийг Лхагва гараг бүрийн 10:00-13:00 цагийн хооронд хүлээн авч шийдвэрлэдэг болсон. Энэ ажлын хүрээнд 2019 оны эхний 6 сарын байдлаар 24 удаагийн уулзалт зохион байгуулахад давхардсан тоогоор 129 иргэн 261 санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл, асуулт гаргасан байна.

Мөн аймгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 2019 оны эхний хагас жилд ирүүлсэн мэдээг аймгийн ИТХ, ЗДТГ, 27 сум, Засаг даргын эрхлэх хүрээний асуудал хариуцсан агентлагуудаас өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэв. Мэдээг хүснэгтээр харуулбал:

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	10	9			1	90.00
2	Аймгийн ЗДТГ	174	114	24		36	79.31
3	Сумд	5487	4567	146	7	728	86.73
4	Харьяа агентлаг, хэлтэс	1131	1041	12	13	65	94.25
Нэгдсэн дүн		6802	5731	182	20	830	87.80

Монгол Улсын Засгийн газраас “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн ажлын аймагт хамааралтай 32 арга хэмжээг нэгтгэн дүгнэж 7 арга хэмжээг 100%, 16 арга хэмжээг 70%, 9 арга хэмжээг 30%-ийн хэрэгжилттэй дундаж 65,31%-ийн хэрэгжилттэй дүгнэн ЗГХЭГ-т хүргэв.

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын удирдах ажилтны нэгдсэн шуурхайг 1 удаа зохион байгуулж, 18 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

2019 оны 6 дугаар сард сум, байгууллагуудад 4 удаа цахим сургалт хийж, зөвлөмж зааварчилгаа өгсөн. Танхимын 7 удаагийн хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын хэвийн ажиллагааг хангасан.

Төрийн албаны стандартын хүрээнд: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу 1980-2012 оны хооронд аймаг суманд ажиллаж байсан төрийн албан хаагчдын хувийн хэргийн бүртгэлийг хийж, архивын баримтын шаардлагад нийцүүлэн хадгаламжийн нэгж үүсгэн 30 баримт бий болгов.

Аймгийн хэмжээнд байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд /үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө/ суурилж төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцох замаар төрийн жинхэнэ албан хаагчдын хагас жилийн ажлын гүйцэтгэл, тайланг албан хаагч бүрээр илтгэх хуудсаар гаргуулан авч дүнг ирүүлэх тухай аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 03/1127 тоот бичгийн дагуу хэлтэс агентлаг, сумдын Төрийн албан хаагчдын дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн Хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

ТАЗСЗ-өөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.06.28-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	11
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	2
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	1
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-
НИЙТ ДҮН		14

2019 оны 05 дугаар сарын 29-ний байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Албан бичиг	155	18	17	1	-
2	Өргөдөл, гомдол	24	24	23	1	-

Тайлант хугацаанд салбар зөвлөлөөс 36 албан бичиг гадагш явуулсан.

Гадаад харилцаа: 2019 оны хагас жилийн байдлаар нийт 12 төрийн албан хаагчид Албан паспорт олгуулав. Бүгд Найрамдах Солонгос улсын Кангвон мужийн Хөдөө аж ахуй газар тариалангийн техник технологийн хүрээлэнгийн Цэцэрлэгжүүлэлтийн албаны орлогч дарга Ом Нам Ёнг тэргүүтэй ажлын хэсэг 6 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд

аймгийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж 16 жил хамтран хэрэгжүүлсэн Хүлэмжийн аж ахуйн төслийн хаалт, “Зуунмод агро парк” шинэ төслийн нээлтийн ажиллагааны бэлтгэлийг хангуулах хүрээнд аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч нартай уулзаж телевизийн ярилцлага, нэвтрүүлгийн бичлэгийг хийв.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Коммунист намын Төв хорооны Гадаад харилцааны газар хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 06 дугаар сарын 24-өөс 07 дугаар сарын 03-ны хооронд БНХАУ-д зохион байгуулагдах аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга нарын сургалтанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга С.Магнайбаяр хамрагдан оролцов.

Бүгд Найрамдах Польш улсаас Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд ноён Кшыштоф Бойко 06 дугаар сарын 05-ны өдөр Төв аймагт зочилж аймгийн Засаг дарга Ж.Батжаргалтай уулзаж, 07 дугаар сард БНПольш улсын Гадаад харилцааны Дэд сайдын хийх айлчлалын хүрээнд Төв аймагт хийх айлчлалын талаар болон аймгийн Баян сум Польш улсын Глиноецк хотын харилцаа хамтын ажиллагааг сэргээх талаар ярилцав. 7 дугаар сард Польшийн Гадаад харилцааны Дэд сайд Төв аймаг, Баян суманд зочилно.

БНСВьетнам улсын Хао Бин мужийн Намын байнгын хорооны Дэд дарга, Хао Бин мужийн Ардын Хорооны дарга, Үндэсний Ассемблей дахь Хао Бин мужийн төлөөлөгч ноён Tran Dang Ninh, тэргүүтэй БНСВьетнам улсын Хао Бин мужийн төлөөлөгчид 06 дугаар сарын 05-ны өдөр аймгийн Засаг даргатай уулзаж, 2 муж аймгийн хооронд хамтын ажиллагаа тогтоох тухай ярилцан тохиров. Аймгийн ИТХ-ын даргатай уулзаж 2 талын Иргэдийн хурлын байгууллагын байнгын Хороодын хооронд хамтран ажиллах санамж бичгт гарын үсэг зурав.

Шууд харилцаат Япон улсын Тоттори мужид 2 сарын хугацаатай Газар тариалангийн дадлагад хамрагдах 1 төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж, Сүмбэр сумын газар тариалангийн мэргэжилтэн Б.Цогзолмааг хамруулахаар болж шаардагдах бүх материалыг бүрдүүлж, Тоттори мужийн Гадаад харилцааны хэлтэст хүргүүлэв.

Монгол улсад зохион байгуулагдсан “Эмэгтэйчүүдийн манлайллын Олон улсын хурал”-д Бутаны Хаант улсаас оролцож байгаа эмэгтэй төлөөлөгчид Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газарт ажиллаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, эмэгтэй төлөөлөгч нар болон Засаг даргын орлогч нартай уулзан, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаатай танилцав.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 06 сарын байдлаар төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 25 байгууллага 300 гаруй төрлийн үйлчилгээг нийт 10,000 гаруй хүнд, өдөрт дунджаар 400-450 хүнд шуурхай хүргэн ажиллаж байна. 06 дугаар сард аймгийн веб сайтад **42**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **57** мэдээ мэдээлэл нийтлэгдсэн байна. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **4** дугаарыг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн байна. Мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар **60-70** мэдээ мэдээллийг давтагдсан тоогоор нийт **200** гаруй удаа олон нийтэд хүргэв. Төвийн мэдээ зурагт нугалбарын 06 дугаар сарын товхимлыг хэвлэж өөрийн байгууллагын иргэдэд үйлчлэх бага танхимдаа байршуулсан. 7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай

холбоотой санал, гомдол 12 ирснийг холбогдох хэлтэс агентлагуудад дамжуулан 100%-ийн гүйцэтгэлтэй шийдвэрлүүлсэн, хугацаа болоогүй 4 гомдол байна.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: 2019 онд 521 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 296 байгууллага буюу 56,8%-ийг хамруулан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 296 байгууллагыг 23 нэр төрлийн хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 37 буюу 12.5% их эрсдэлтэй, 120 буюу 40.54% нь дунд эрсдэлтэй, 139 буюу 46,96% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1107 заалттай 130 албан шаардлагаар үүрэг өгч биелэлтийг хангуулан ажилласан. Хүнсний зах, томоохон худалдааны төв, хүнсний дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүний хэрэглэх, хадгалах хугацаа дууссан 240 нэр төрлийн 30.15 кг, 4584 ширхэг, 3727327 төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн 25 актаар хураан авч устгалын комисст шилжүүлсэн. Нийт 70 дүгнэлт гаргаснаас барилгын зурагт эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж улсын байцаагчийн зөвшөөрсөн 13, татгалзсан 4, бүтээгдэхүүний 46, үйл ажиллагааны 7 дүгнэлт гаргасан байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 9 сард хийхээр төлөвлөөд байна.

Тус газар нь 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу зөвлөн туслах үйлчилгээнд 170 оюуект хамруулахаас 111 байгууллага буюу 65,3% хамруулан зөвлөн туслах үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Эрсдэлийн үнэлгээгээр дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 111 объектыг холбогдох нэр төрлийн хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 14 буюу 12,6 % их эрсдэлтэй, 46 буюу 41.44% нь дунд эрсдэлтэй, 51 буюу 45,94% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 318 заалттай 62 зөвлөмжөөр үүрэг өгч биелэлтийг хангуулан ажилласан.

Тайлант хугацаанд 8 сэдвээр салбарын сургалт зохион байгуулж аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 510 хүнийг хамруулсан байна.

Итгэмжлэгдсэн лаборатори нь 2019 оны хагас жилийн байдлаар 1284 сорьцод 5988 үзүүлэлтээр 20,573.700 төгрөгийн ажил үйлчилгээ явуулж, үүнээс дансанд төвлөрсөн 4,011.100 төгрөг, хяналт шалгалтаар төлбөргүй 16,562.600 төгрөгийн шинжилгээ хийгдсэн. Нийт сорьцын 257 буюу 20,1% нь чанар стандартын шаардлага хангахгүй гарсан байна. Тайлант хугацаанд шинжилгээний хариуны хоцролтгүй ажилласан. Шинжилгээнд хамрагдсан сорьцын 88,2%-ийг төлөвлөгөөт болон бусад хяналт шалгалтын, 11,8 %-ийг ААН, иргэний хүсэлтийн сорьц эзэлж байна.

Онцгой байдлын газрын хүрээнд: 2019.06.14-ний Төв аймгийн шууд харилцаат БНСУ-ын Кангвонь мужийн ИТХ-аас бэлэглэсэн гал унтраах автомашиныг Онцгой байдлын газраас Жаргалант суманд, Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгээр Батсүмбэр, Баянчандмань, Жаргалант, Сүмбэр, Борнуур сумын Гал түймэртэй тэмцэх бүлэгт гал унтраах иж бүрдлийг Аймгийн ИТХ-ын дарга Ц.Энхбат, Аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, Аймгийн онцгой комиссын гишүүд хүлээлгэж өгсөн.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 27 байгууллага, аж ахуйн нэгж шалгаж гамшиг осол гал түймэр гарч болзошгүй 124 зөрчил дутагдлыг илрүүлэн, газар дээр нь 34 зөрчлийг засуулан 90 зөрчилд Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 15, мэдэгдэл 2 бичиж холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан байна. Аж ахуйн нэгж, байгууллагад гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа, дадлагыг 1 удаа хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Төв аймгийн Эрдэнэ сумын Баянтуул 3 дугаар багийн нутаг Ар хучингийн ам гэх газар ойн түймэр, Зуунмод, Сэргэлэн, Эрдэнэ, Батсүмбэр, Жаргалант, Борнуур сумдад тус бүр нэг объектын гал гарсны унтраасан байна. 2019 оны 06 дугаар сарын 15,16-ны өдөр Аргалант Баянхангай, Лүн, Сэргэлэн зэрэг сумдын нутаг дэвсгэрт хүчтэй аадар бороо орсны улмаас 2х3 хэмжээтэй байшин 4 гэр тавилга, 240 бод 1012 бог нийт 1252 толгой мал, 17 айлын хашаа, хөв цөөрөм усан урсаж 70% шороо дүүрсэн, сумын жижиг гүүр нурсан, тариан талбай 480 га үерт автсан гамшиг тохиолдож, хувийн өмчид 899,784,000 төгрөгийн хохирол учирсан байна.

Ус, цаг уур, эрдэм шинжилгээний газраас ирүүлсэн мэдээллийн дагуу их хэмжээний бороо орж болзошгүй зам даваа хаагдаж үер бууж болзошгүй тул заасан хугацаанд тус бүс нутаг руу замд гарахгүй байхыг зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад орон нутгийн болон бусад мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан сэрэмжлүүлэг тараан, үер усны дуудлагын дагуу цаг тухайд нь мэргэжлийн анги болох “Төв АЗЗА” компанитай хамтран хойшлуулушгүй арга хэмжээ авч, иргэд, зорчигч, автомашины хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллалаа.

Эрэн хайх аврах салбарын шуурхай албаны автомашин болох УАЗ фургон 18-32 төв маркын машинд хэт богино долгионы радио станц icom 320 маркын станцыг суурилуулаж радио холбоо дамжуулах чадамжийг нэмэгдүүлсэн.

Байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардал, материалыг батлагдсан төсвийн хүрээний дагуу зарцуулан, санхүүгийн анхан шатны материалын бүрдлийг ханган, төсвийн гүйцэтгэлийн 05 дугаар сарын мэдээг тайлагнан өр авлагын мэдээний хамт аймгийн Төрийн санд хүргүүлэн баталгаажуулан сангийн яамны цахим сайтад байршуулсан.

ОБГазрын Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн ахлах дэслэгч Л.Дашлхагва хүндээр өвдсөн, Зуунмод сумын УНХТАнгийн Цээл сум дахь УНЦэгийн харуул О.Шинэбаярны төрсөн ээж нас барсан, ГТУАврах 24-р ангийн шуурхай удирдлагын оператор дэд ахлагч А.Тогтохбаярын төрсөн эмээ нас барсан тул 100.000 төгрөгний тэтгэмжийг тус тус олгосон байна.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Төв аймагт “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” 06 дугаар сарын 18-наас 25-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Улсын үзлэгт аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Баянжаргалан, Баян, Зуунмод сум хамрагдаж, 12 байгууллагад зөвлөмж өгч ажиллалаа. Улсын үзлэгийн дүнгээр Төв аймгийн ИТХ-ын ажлын алба 86.0%-тай буюу (В) сайн, ЗДТГ 92.0%-тай буюу (А) маш сайн үнэлгээ авлаа.

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019-2020 оны аймгийн төлөвлөгөөг баталгаажуулан сум, байгууллагад хүргүүлж, сумдын ухуулагч, эрх зүйн хөтөч нарт 06 дугаар сарын 10-30-ны хооронд 4-6 цагийн сургалт зохион байгууллаа.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 06 дугаар сарын дугааруудыг бэлтгэн нийтэд хүргэв.

Хууль сурталчлах сарын ажлын хүрээнд 06 дугаар сард Боловсролын тухай хууль тогтоомж, Захиргааны ерөнхий хууль тогтоомж сурталчлах 21 хоногийн ажлыг сум байгууллагуудын хэмжээнд үүрэг чиглэл өгч зохион байгууллаа.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран Баянчандмань, Батсүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, сумдад “Газрын хууль тогтоомж”-ийн хэрэгжилтэд шалган зөвлөх ажлыг зохион байгуулж, энэ чиглэлээр гаргасан захирамж шийдвэрийг хянах, арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Хүний эрхийн үндэсний комиссын Төв аймаг дахь төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран “Хүний эрхийн тухай”, “Хөдөлмөрийн харилцаанд анхаарах асуудал”, “Эвлэлдэн нэгдэх эрх”, “Жендерийн тэш байдал ба жендерт суурилсан хүчирхийлэл” сэдэвт сургалтыг 5 суманд 06 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд бүсчлэн зохион байгуулж, нийт 256 албан хаагчдыг хамрууллаа. Сургалтын үеэр 20 малчин эмэгтэйчүүдээс “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр асуумж, санал авч ажиллалаа.

Төрийн архивын эх баримтаас 140 иргэний хүсэлтээр 288 хуулбар хувь, 90 лавлагаа, 161 хөмрөгийн 648 хадгаламжийн нэгж ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлж, 638.0 төгрөгийн орлого төвлөрүүллээ. 2 хөмрөгийн 236 хадгаламжийн нэгжийн 6028 хуудас баримтын 22533 хүний нэр, 4821 заалтын тоо, 4821 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж PDF.JPEG хэлбэрт хувирган өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ. 2 хөмрөгийн 236 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийлээ.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

06 дугаар сард цахим санд нийт 50485 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9517, газар өмчлөх эрхийн 40968, нийт хүлээн авсан мэдүүлэг 19795 байна. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 113.7 сая, үл хөдлөх худалдан борлуулсны орлогоос 76.6 сая, тэмдэгтийн хураамжаас 2.7 сая төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

06 дугаар сард нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нийт 134 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 100 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 35, хууль хяналтын байгууллагад 34 лавлагаа мэдээлэл тус тус өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 6.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

2019 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар 360 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90 нэгжээр буюу 25.0 хувиар, зөрчил 22744 бүртгэгдэж 7463 нэгжээр буюу 32.8 хувиар тус тус өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 37.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.7 хувиар өссөн. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11.2%, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 23.8%, үүнээс мал хулгайлах гэмт хэрэг 65.5%, Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 52.3%-иар тус тус өсч, гэр бүлийн хүчирхийлэл 9.1%, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг 42.8%-иар тус тус буурсан.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор Цагдаагийн төв байгууллагаас улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Орон нутгийн зам-хөдөлгөөн соёл 2019”, “Бяцхан зорчигч”, “Яараад яахав дээ”, “Шийдвэрлэлт-2019”, “Цахим”, “Камерын хяналт” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Гудамж талбай, олон нийтийн газар болон гэр орон, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгслэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон, шүүхээр баривчлагдсан, албадан саатуулагдсан нийт 105 иргэнийг эрүүлжүүлж, 5 иргэнд эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж, ар гэр, асран хамгаалагчид нь 9 иргэнийг хүлээлгэн өглөө.

Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад 3 удаа, 24 алба хаагч, 6 тээврийн хэрэгсэлтэй, 24 тусгай хэрэгсэл, 3 холбооны хэрэгсэлтэй, 41 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, 1030 иргэний аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 56 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 15 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэлээ. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5768 жолоочийг 150.0 сая төгрөгөөр торгосон.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр: 06 дугаар сард криминалистикийн шинжилгээ 100, нийт хийсэн магадлан шинжилгээ 83, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр 268, гарын мөрийн санг баяжуулсан 152, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 401-ийг гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
06-р сар	398	256	18	636	270	366	42.5
	3920610.2	2301951.2	531308.2	5691253.2	1159291.7	4531961.5	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүрээнд: Зуунмод сумын Соёл амралтын хүрээлэнд 1000 м² талбай бүхий “Хүлэмжийн цогцолбор парк”- шууд харилцаат БНСУ-ын Кангвон мужтай хамтран барьж ашиглалтад орууллаа.

06 дугаар сарын байдлаар үр тариа 69148 га буюу 76.28 хувьтай, үүнээс улаан буудай 63788га 76,85 хувьтай, тосны ургамал 18679 га, төмс 7704,91 га буюу 128.63 хувьтай, хүнсний ногоо 1069,03 га-д тариалж 76.36 хувьтай, тэжээлийн ургамал 7594.78га-д 90,13 хувьтай байна.

06 дугаар сарын 15-16-нд орсон хүчтэй аадар борооны улмаас Аргалант, Баянхангай, Лүн, Эрдэнэсант, Баянцогт, Сэргэлэн сумдад 2817 га талбайн улаанбуудай, 1147 га тосны ургамал, 21,5 га талбайн хүнсний ногоо үерт автсан. Үерт орсон талбайг таримлын төрөл, аж ахуйн нэгж иргэнээр гарган ХХААХҮЯ, аймгийн ОБГазарт хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд төллөх насны хээлтэгчийн 80.1% буюу 1778.1 мян хээлтэгч мал төллөж, 1787.5 мян төл хүлээн авснаас 98.6% 1744.4 мян төл бойжиж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 26 суманд 36 инженерийн хийцтэй худаг шинээр гаргахаас одоогийн байдлаар 11 суманд 16 худаг шинээр гарган гүйцэтгэл 33 хувьтай байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 12 төрлийн вакцинжуулалтад 1467.8 мян толгой мал хамруулахаар төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 954.1 мян толгой малыг хамруулж 65%-ийн гүйцэтгэлтэй, эм био бэлдмэлийн нийлүүлэлт 68%-тай хэрэгжиж 23 удаагийн дуудлагаар мал эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Шимэгч тэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний туулгалтад 1100.0 мян мал хамруулахаас 852,4 мян мал буюу 77,4%, боловсруулалтад 1100.0 мян мал хамруулахаас 768.3 мян мал буюу 69,8%-ийг хамруулсан.

Гоц халдварт, халдварт, шимэгч тэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн Засаг даргын А/350 дугаар захирамжаар “Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн сарын аян”-ыг 06 дугаар сарын 07-ны өдрөөс 07 дугаар сарын 07-ны хооронд зохион байгуулж, сум бүрт суперкилл 2кг-ийг олгон одоогийн байдлаар түүхий эдийн 10 цэгийн 627м², 633 хашаа хорооны 82,9 мян м², 75 худаг уст цэгийн 2.1 мян м², голомт, устгалын цэгийн 6.6 мян м², 8773 сэг зэмийн 3.4 мян м² нийт 95.7 мян м² талбайд халдваргүйтгэл хийгээд байна. Аймгийн Засаг даргын А/375 тоот захирамжаар гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 129.8 мян бод, 1063.6 мян бог мал хамруулахаар төлөвлөн 10 сумын 40 МЭҮН-д хуваарилан вакцинжуулалт 32%-тай байна.

Байгалийн гамшигт үер усны аюулд өртсөн Баянхангай сумын 29 өрхийн 3820 мал, Лүн сумын 1 өрхийн 742 мал хорогдсон ба малын сэг зэм устгах, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээнд аймгийн нөөцөөс 325кг хлорын шохой, 22кг суперкилл, 1ш-автомат автомакс зэргийг олголоо. Сэг зэм устгах нүхийг ухах ажил хийгдэж байна.

Лүн сумын МЭХЦХЦ-ийн хяналтын цэг нь 604 тээврийн хэрэгсэл, тэмээ 174, адуу 1123, үхэр 539, хонь 2678, ямаа 255 толгой, мах, махан бүтээгдэхүүн 7.4 тн, арьс шир 6035 ш, ноолуур 82,6тн, ноос 5.8 тн зэрэг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгосон байдлыг шалган, 604 машин, 781.6м² талбайг ариутгал халдваргүйтэл хийж, 22 зөрчилтэй тээврийн хэрэгслийг илрүүлэн арга хэмжээ авч ажиллалаа.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын хамтарсан удирдамжийн дагуу “Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэг” зохион байгуулж, 27 сумын СХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийж, аймгийн хэмжээнд 74 оноо буюу 66.7 хувьтай дүгнэсэн. Үзлэгийн дүнгээр нийт 2011-2019 оны 5194 иргэний зээлийн мэдээллийг баталгаажуулж, үүрэг чиглэл өгч ажиллалаа.

ХХААХҮЯ-ны сайдын 2019 оны А/119 тоот тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын дагуу аймгийн дэд хороонд 38иргэн, ААН-ийн 2.493.451.180 төгрөгийн дүн бүхий төслийн материалуудыг хүлээж авч, ХХААХҮЯ-ны ЖДҮХС-ийн office.smefund.gov.mn-н цахим программд төслийн материалуудын мэдээллийг бүртгэж баталгаажуулав.

Дэлхийн сүүний өдрийг “Өдөрт нэг аяга сүү- Нэг аяга тараг” уриан дор Эрдэнэ сумын МСҮТ-ийн “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех”-ийг түшиглэн анх удаа тэмдэглэлээ. Тус арга хэмжээнд аймгийн ЗДТГ, ХХААГ, БНЧУ-ын ЭСЯ, НҮБ-ын ХХААБ, олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл, Эрдэнэ сумын удирдлагууд, багш сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд нийт 1000 гаруй төлөөлөл оролцлоо. УБ хотод зохион байгуулагдсан “Чингис хааны цом-2019” олон улсын хоолны фестивалд Зуунмод, Батсүмбэр сумын 3 тогооч оролцож “Монгол зоог” зоогийн газрын тогооч Б.Оролзод “Ази хоолны төрөл”-д хүрэл медаль, Баянбуурал амралтын газрын тогооч Г.Гантуул “Европ хоолны төрөл”-д тусгай байр эзэллээ.

Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 87 төсөл арга хэмжээнд 43244.2 сая төгрөгийг баталж, 63 төсөл арга хэмжээнд тендер шалгаруулалт зохион байгуулахаас 38893.5 сая төгрөгийн 58 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж хэрэгжилт оны эхний хагас жилийн байдлаар 92 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 2019 онд улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар нийт **46,8** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдсөн. Үүнээс аймагт эрх шилжиж ирсэн, аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байгаа **25,9** тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий **98** төсөл, арга хэмжээ байна. 4 төсөл, арга хэмжээний тендерийг ТӨБЗГазраас тендер зарлах ба үүнээс 1 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан, 2 төсөл, арга хэмжээний тендер зарлагдаж үнэлгээний шатанд байна. 1 төсөл, арга хэмжээ зураг төсөл магадлалын шатанд байна.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: 06 дугаар сард 10 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталж, 11 барилгын эх загвар болон ажлын зураг төсөлд зөвшөөрөл олгож, 11 барилга байгууламжид барилга эхлүүлэх зөвшөөрөл олгож, 4 барилга байгууламж ашиглалтад өгснөөр 2019 оны эхний хагас жилийн байдлаар 19 барилга байгууламж ашиглалтад орлоо. Мөн хот байгуулалтын сүлжээний мэдээллийн санд 5 барилга байгууламжийг бүртгэн акт өгч ажиллаа.

Хот, суурин газрын өнгө төрх, гэрэлтүүлэг чимэглэлийг сайжруулах зорилгоор байгууллага, аж ахуйн нэгжийн барилгын фасадны гэрэлтүүлгийн зураглалыг батлах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд зураглал хийх, боловсруулах, батлах, материалын тооцоо гаргах ажил хийгдэж байна. Эхний ээлжинд Монгол туургатан театр, Аймгийн ЗДТГ, Төр захиргааны II байр, ГХБХБГ-ын гадна гэрэлтүүлгийн ажлын зураглал гарган ГХБХБГ-ын иж бүрэн гэрэлтүүлгийг “Цацрах хангай” ХХК хийж хүлээлгэн өгсөн. Цаашид бусад байгууллагуудыг гадна тохижилт, засвар, гэрэлтүүлэг, хаягжуулалтыг хийлгүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 1177 иргэнд 218,9га газар өмчлүүлэв. Игэснээр өссөн дүнгээр аймгийн хэмжээнд газар өмчлөлийн явц 66,2 хувьтай 63225 иргэнд 11593,3 га газрыг өмчлүүлэв. Аймгийн газрын төлбөрийн төлөвлөгөөний сар улирлын хуваарийн дагуу 06 дугаар сард 97583.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. 2020 оны газрын төлбөрийн төлөвлөгөөний төслийг маягтын дагуу 2019 оны 06 дугаар сарын 17-21-ний хооронд сумдаас нэгтгэн авсан. Үүний дагуу газрын дутуу төлбөр болон 2012 оноос 2019 он хүртэл хүчингүй болсон захирамжуудыг татварын хэлтэстэй хамтран татварын праграммд бүртгэлтэй байгаа иргэн, аж ахуй нэгжийг хасуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд: Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан улсын хэмжээнд зохион байгууллагдаж байгаа зочлох үйлчилгээ сургалтыг төв аймгийн ЗДТГ, БОАЖГ, Аялал жуулчлалын ур чадварын төв хамтран 06 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд 8 сургагч багш 10 чиглэлээр зохион байгуулж 102 хүн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны гэрчилгээтэй болов.

Аялал жуулчлалын улирал эхэлсэнтэй холбогдуулан авто зам дагуу цэвэрлэгээг зохион байгуулж 06 дугаар сарын байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 75 ААН, 790 иргэний оролцоотой 124 тн хог хаягдал, 570 малын сэг зэмийг цэвэрлэж нийт 7,5 сая төгрөгийг зарцуулсан.

“Амьд амьтан асрал” ТББ-аар гүйцэтгүүлэн Хустайн байгалийн цогцолборт газраас Баян сумын орон нутгийн тусгай хамгаалалттай Баянгийн ууланд 17 эр 26 эм 7 мөндөл нийт 50 толгой монгол тарвага сэргээн нутагшуулав.

Канад улсын мерит төсөлтэй хамтран уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагуудын хандив, нөхөн сэргээлтийн гэрээ, татварын орлого зэрэг уул уурхайн цаг үеийн мэдээ мэдээллийн нэгдсэн сантай болох ажлыг амжилттай хэрэгжүүлэн <http://mining.to.gov.mn/> сайтыг ашиглалтад оруулав.

Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээнд: Өмнөх оны мөн үед аймгийн нутгийн 50 орчим хувьд зуншлага хэвийн, 50 гаруй хувьд зуншлага дунд буюу муу байсан бол 2019 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар нутгийн 10 хүрэхгүй хувьд зуншлага хэвийн, бусад сумдын нутгаар зуншлага дунд буюу муу бэлчээрийн ургамал оройтож цухуйсан, ургалт удааширч гандах төлөвтэй болсон байна. Бэлчээрийн ургамлын дундаж өндөр, см 2019 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар Угтаал, Лүн сумдын нутгаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр 6-10 см, бусад сумдын нутгаар 0-5 см байна. Өмнөх оны мөн үед Угтаал, Лүн сумдын нутгаар 10-15 см, Заамар, Цээл, Жаргалант, Борнуур, Аргалант сумдын нутгаар 6-10 см, бусад сумдын нутгаар 0-5 см дундаж өндөртэй байв. Буудай тариалсан талбайд Эрдэнэсант сумын нутгаар 0-20 см, 0-50 см-ийн гүнд дунд зэрэг, Угтаал сумын нутгаар 0-20 см, 0-50 см-ийн гүнд хангалтгүй.

Төмс тариалсан талбайд 0-20 см-ын гүнд Борнуур, Баянчандмань сумдын нутгаар чийгшил хангалттай, Жаргалант, Угтаал сумдын нутгаар хангалтгүй, 0-50 см-ийн гүнд Угтаал, Баянчандмань, Жаргалант сумдын нутгаар дунд зэрэг, Борнуур сумын нутгаар хангалттай байна.

Төв аймгийн нутаг дэвсгэрт 7 ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2019 оны 06 дугаар сарын 21-ний байдлаар усны түвшин Туул гол Туул-Алтанбулаг харуулд 545 см, Туул-Лүн харуулд 111см, Туул-Заамар харуулд 208см байна. Хэрлэн голын усны түвшин Хэрлэн-Хонгон харуулд 130 см, Хэрлэн-Мөнгөнморьт 126 см, Сөгнөгөр голын түвшин Сөгнөгөр-Сөгнөгөр харуулд 197 см, Шивэрт гол Шивэрт-Борнуур харуулд 136 см тус тус байгаа нь өмнөх оны 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөртэй харьцуулахад Туул гол 8-40 см их, Хэрлэн гол 1-9 см-ээр их, Сөгнөгөр гол Сөгнөгөр-Сөгнөгөр харуулд 5см бага байна.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

2019 оны 06 дугаар сарын 07-нд Нийгмийн бодлогын хэлтсийн харьяа байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг Зуунмод сумын Зүүндэлгэр IV багт зохион байгуулж, өдөрлөгийн хүрээнд багийн шинэ байрны нээлтийн ажиллагаа, байгууллагын танилцуулга мэдээлэл хийж, давхардсан тоогоор 1720 иргэнд нийгмийн салбарын харьяа байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчилан, мэдээлэл хүргэж ажиллалаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийг дэмжих 21 аймгийн сайн туршлагыг танилцуулах, харилцан суралцах семинар 06 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж Төв аймгаас Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, Борнуур сумын Засаг дарга, нийгмийн бодлогын мэргэжилтэн 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2 эмэгтэй, 2 эрэгтэй албан хаагч оролцож байгаль орчноо хамгаалах чиглэлд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явцын талаар танилцууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох аймгийн комиссоос “Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх нь” сэдэвт аймгийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнийг 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймаг, орон нутгийн удирдлагууд, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд нийт 63 хүн оролцон илтгэл мэдээлэл танилцуулж, аймгийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын холбоог 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн, тэргүүнээр “РТА” эмийн сангийн захирал Р. Очирбат сонгогдов.

Боловсрол, соёл, урлагийн газрын хүрээнд: 2019 оны улсын шалгалтын дүнгээр 5-р ангийн улсын шалгалтын гүйцэтгэл 77,15%-д хүрч өмнөх оноос 3,42 пунктээр ахисан. 9-р ангийн гүйцэтгэл 74,74%, өмнөх оноос 1,15 пунктээр, 12-р ангийн гүйцэтгэл 76,22%, 0,94 пунктээр тус тус буурсан байна. Улсын шалгалтын нийт гүйцэтгэлийн хувь 75,8%, өмнөх жилээс 0,13 пунктээр буурсан. БСШУСС-ын А/425 тушаалаар шинэчлэгдэн хэрэгжиж байгаа "Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх дүгнэх журам"-д заасан 8 түвшний үнэлгээний 7-8-р түвшинг АВ-ийн эзлэх хувьд дүйцүүлэн тооцоход 2019 оны улсын шалгалтын суурь, бүрэн дунд боловсролын АВ-ийн эзлэх хувийн дундаж 45,72%-тай шалгагдаж зорилтот түвшнээс 6,28 пунктээр доогуур байна. 6-11-р ангийн суралцагчдыг хамруулан заавал өгөх, сургууль сонгох, нэгдмэл агуулгаар анги дэвших шалгалтыг зохион байгуулснаар шалгалтын гүйцэтгэлийн хувь 73,21%-д хүрч өмнөх оноос 0,04 пунктээр ахисан.

2019 оны ЭЕШ-ын урьдчилсан дүнгээр /21 аймгийн хэмжээнд/ түүх 584,5 оноотой 2-р, биологи 526,5 оноотой 3-р, хими 506,5 оноотой 4-р, газарзүй 544 оноотой 7-р, нийгмийн тухай мэдлэг 512 оноотой 7-р, орос хэл 485 оноотой 6-р, англи хэл 472 оноотой 45-р, математик 482,09 оноотой 18-р, физик 486,9 оноотой 13-р, монгол хэл 499,1 оноотой 9-р байрт эрэмбэлэгдсэн үзүүлэлттэй байна.

24 сумын 37 цэцэрлэгийн тогооч, 2 эрхлэгч, БСУГ-ын 1 мэргэжилтэн нийт 40 албан хаагчдыг хамруулан ОХУ-ын Буриадын Улан-Үдэ хотын аялал жуулчлал, хүнсний технологийн коллежид 2 өдрийн мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан.

Борнуур, Лүн, Зуунмод 5-р сургуулийн захирал, сургалтын менежер, багш, БСУГ-ын 1 мэргэжилтэн нийт 7 төлөөлөгчид БНСУ-ын Инчёны боловсролын газрын хамтын ажиллагааны хүрээнд туршлага судалсан.

Аймгийн хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд суурь боловсрол эзэмшсэн 1189, бүрэн дунд боловсрол эзэмшсэн 269 суралцагчдад суурь бүрэн дунд боловсролын гэрчилгээ, үнэмлэх олгож БСШУСЯ-нд “Б маягт”-ыг хүргүүлж тайлагнасан.

Албан бус насан туршийн боловсролын төвийн хүрээнд: Энэ оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 8-42 насны нийт 385 иргэн хамрагдан суралцсанаас 365 суралцагч буюу 94,8% нь тухайн шатны боловсролыг нөхөн эзэмшсэн. Бага боловсрол 24, Суурь боловсрол 72, Бүрэн дунд боловсрол 60, нийт 156/42,7%/ суралцагч төгссөн. Дүйцсэн хөтөлбөрийн

төгсөлтийн үр дүн өмнөх онд 87,5% байсан бол энэ хичээлийн жилд 94,8% болж 7%-иар нэмэгдсэн.

Монгол туургатан театрын хүрээнд: Монгол туургатан театраас 12 удаагийн урлаг, соёл, бусад арга хэмжээг амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор 2500 гаруй иргэд, төрийн албан хаагчид үйлчилсэн. 06 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас зохион байгуулсан “Азийн ардын урлагийн их наадам”-д тус театраас хөгжимчид, бүжигчид, дуучид зэрэг нийт 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймаг, орон нутгаа төлөөлөн амжилттай оролцсон.

Монгол туургатан театраас санаачлан Улаанбаатар дахь Хятадын соёлын төвийн дэмжлэгтэйгээр аймгийн сумдын Соёлын төвийн эрхлэгчид болон соёл урлагийн байгууллагуудын албан хаагчид нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй баг 2019 оны 06 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Хөх хот”-д туршлага солилцох аялалыг зохион байгууллаа.

Музейн хүрээнд: Төв аймгийн музей түүний салбар музейгээс 06 дугаар сард нийт 2628 үзэгчдэд үйлчлэн, 3477500 төгрөгийн орлого төвлөрүүлж ажиллалаа. 06 дугаар сарын 13-ны өдөр Говьсүмбэр аймгийн Боржигин өв музейтэй хамтран "Соёлын өвийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, судалгааны талаар" туршлага солилцох дадлага, сургалт зохион байгууллаа. Уг сургалтад хоёр музейн хамтарсан 15 албан хаагч оролцлоо.

06 дугаар сарын 20-ны өдөр БСШУСЯ, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны хүрээлэн, ЗГХАгентлаг Соёл урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төвөөс Улаанбаатар хотод хамтран зохион байгуулсан “Соёлын өв- архитектурын дурсгалыг гамшиг, эрсдлээс хамгаалах нь” зөвлөгөөнд захирал, бүртгэл мэдээллийн санч, аргазүйч нар хамрагдсан. Энэ ажлын үргэлжлэл болгон Солонгос улсын мэргэжилтэн нар Манзушир дахь салбар музейтэй танилцан авран хамгаалах талаар зөвлөгөө өгсөн. Мөн Соёлын өвийн Үндэсний төвөөс Манзушир дахь музей болон дурсгалт зүйлсийг агаараас дроноор зураг авч бүртгэн баримтжууллаа.

Нийтийн номын сангийн хүрээнд: 06 дугаар сард **390** байнгын уншигч, ирэгсэд, нийт **1345** уншигчдад **3850** ном олгон уншуулж, 2 төрлийн дугуйланд нийт 48 хүүхдийг хамрууллаа. Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдэд үйлчлэх тоо, чанарыг ахиулах зорилгоор Баянцагаан сумын соёлын төвийн номын санчтай хамтран **2** багийн **42** иргэнд **67** ном олгож уншуулсан.

“Уншлагыг дэмжье” аяны хүрээнд Зуунмод сумын Хүмүүн цогцолбор цэцэрлэгийн **3** бүлгийн **66** хүүхэд багачууд, эцэг эхийн хамт номын сангийн үйл ажиллагаатай танилцаж үлгэрийн цагаар аяллаа.

Үндэсний номын сангийн “Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан”-д Төвийн мэдээ сэтгүүлийн 2019 оны 1-5-р сарын 83 ширхэг мэдээллийг zotero программд шивж оруулсан.

Биений тамир, спортын газрын хүрээнд: 06 дугаар сард 1 олон улсын, 2 аймгийн аварга шалгаруулах тэмцээн, 19 бусад арга хэмжээ зохион байгуулж, 2251 тамирчин хамруулан олон улсын тэмцээнээс 7, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 9 медаль хүртлээ. Заамар суманд боксын тэмцээн зохион байгуулж, 3 орны 21 байгууллагын 114 тамирчин оролцлоо. Монголын тамирчдын өдөр, олон улсын олимпын өдрийг тохилдуулан Төв аймгийн БТСГ-ын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019.06.22-ны өдөр зохион байгуулж спортын 4 төрлийн арга хэмжээнд 116 тамирчинг хамрууллаа.

Үндэсний сурын харвааны өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж 4 сумын өсвөрийн 11, насанд хүрэгчдийн 18 нийт 29 харваач оролцсон. Мини волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 20 сумын 58 багийн 311 тамирчин оролцож улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 насны ангиллаар 24 тамирчин оролцож хагас шигшээд шалгарсан амжилтыг үзүүллээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүрээнд: Аймгийн Засаг даргын 2019 оны А/314 дугаар захирамжаар Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг томилон “ХҮҮХЭД ГЭР БҮЛДЭЭ ЖАРГАЛТАЙ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн. Хүүхдийн баярын арга хэмжээний хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд аймаг, бүс, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн 148 хүүхдэд Аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний нэрэмжит “Амжилтын од” медалийг гардууллаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санаачилгаар бүтээгдсэн "БИ НАР" гэр бүлийн уран сайхны киног 160 гаруй хүүхэд багачууд, эцэг эхчүүдэд үнэ төлбөргүй үзүүлж, хүүхдийн баярын арга хэмжээний хүрээнд “Дэлхийн сүүний өдөр”-ийг хамтатган тэмдэглэж Эрдэнэ сумын МСҮТ-ийн сүү боловсруулах цехийн хандивласан 1000 ширхэг таргийг үнэгүй тараасан. Хүүхэд багачуудад зориулан шинэ номын үзэсгэлэн худалдаа, 2 төрлийн автомат тоглоом, музейн үзвэр, хүүхэдэд кино, түргэн хоолны цэг, худалдаа үйлчилгээний байгууллагаар давхардсан тоогоор 1850 гаруй хүүхэд, багачууд үйлчлүүлсэн ба хүүхэд хамгааллын зардлаас 3,945,400 төгрөг, Дэлхийн Зөн ОУБ-ын Төв ОНХ-өөс 4,540,000 төгрөг зарцуулав.

“Хүүхдээ сонсох” өдрөөр 2018-2019 оны хичээлийн жилд аймаг, бүс, тив дэлхийн чанартай уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн 148 хүүхэд, аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний нэрэмжит “Амжилтын од” медалиар шагнагдсан сурагчдын төлөөлөлтэй уулзсан. Уулзалтаар 7 хүүхэд санал, 1 хүүхэд талархал илэрхийлсэн.

2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил хамгааллын жил болгон зарлах тухай” Засгийн газрын 210 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор жилийн ажлын нээлтийн үйл ажиллагааг аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөл, Дэлхийн Зөн ОУБ-ын Төв ОНХ-тэй хамтран зохион байгуулж, зөвлөгөөнд 22 сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүн, гэр бүлийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 270 өрхийн төлөөлөл эмэгтэйчүүд, нийт 150 гаруй төлөөлөгчид өөрийн дуу хоолой, санал бодлоо илэрхийлэн оролцсон.

2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн орсон аадар борооны улмаас үер бууж үерт гэр орон, үр хүүхэд, бусад зүйлээ алдсан Баянхангай сумын 6 өрхөөр айлчилж нөхцөл байдлын үнэлгээ хийн, гэр бүлд болон 12 хүүхдэд шаардлагатай үйлчилгээний жагсаалтыг гарган Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-т хүргэсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн хүрээнд: 2019 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоо, өссөн дүнгээр 1849 иргэнд 1800,5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1169 иргэнд 774,8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1062 иргэнд 333.4 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 1250 ахмад настанд 197,5 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 354 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 64,7 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, алдар цолтой 60 ахмад настанд 55,2 сая төгрөгийн хөнгөлөлтийг олгосон.

Алдарт эхийн 1-р одонтой 3083 эхэд 616.4 сая төгрөг, 2-р одонтой 5836 эхэд 583.6 сая төгрөг, нийт 8919 эхэд 1200.0 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарч буй 5296 эхэд 1418.0 сая төгрөгийн тэтгэмж, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1444 эхэд 182.0 сая төгрөгийн тэтгэмж, 13 эхэд 26.0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмж, 18 хүртэлх насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 251 эх /эцэг/-д 159.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Насны хишгийг 65-69 насны 1944 ахмад настанд 97.2 сая төгрөг, 70-79 насны 2083 ахмад настанд 166.6 сая төгрөг, 80-89 насны 743 ахмад настанд 111.1 сая төгрөг, 90-с дээш насны 104 ахмад настанд 25.7 сая төгрөг нийт 4874 ахмад настанд 400.6 сая төгрөг олгож, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа 1321 өрхийн 3603 иргэн, 3669 хүүхдэд 514.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 4-р зөвлөгөөнийг 06 дугаар сарын 07-нд зохион байгуулж 27 сумын 95 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж дэд бүтэц, эмнэлэг болон бусад

үйлчилгээний хүртээмжтэй байдлыг сайжруулах чиглэлээр 16 санал гарсныг холбогдох байгууллагад уламжилсан.

Өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй 28896 хүүхдэд 577,0 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эрүүл мэнд нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаа хуралдаж, хөгжлийн бэрхшээлтэй 18 хүүхдийг байнгын асаргаатай болохыг тогтоож, СӨБ, Тусгай сургуульд 2 хүүхэд, ЕБС-д 1 хүүхдийг сургахаар чиглэл өгч ажилласан. ХХҮЕГазраас зохион байгуулсан “Хүүхдийн хөгжилд-мэдээллийн технологи” үндэсний уралдаанд Хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдийг оролцуулснаар алтан медаль авч, олон улсын тэмцээнд оролцох эрх авсан. Зуунмод сумын ХБХүүхдийн дунд “БҮХ ХАЙРАА- БЯЦХАН ХҮҮХДҮҮДЭД” арга хэмжээг зохион байгуулж үйл ажиллагаанд 20 хүүхдүүд оролцож бэлэг гардан авсан.

Нийгмийн даатгалын хүрээнд: Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК 4 удаа, 19 цаг хуралдаж, нийт 158 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 119 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 16 иргэнийг цуцалсан байна. Аймгийн хэмжээнд 13831 тэтгэвэр авагчдад 06 дугаар сард 5.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 103 иргэнд 8.4 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, 94 даатгуулагчид жирэмсэн, амаржсаны 48.6 сая төгрөгийн тэтгэмж, 10 иргэнд 10.0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж, 34 даатгуулагчид 25.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж, нийт 92.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/91 дугаар тушаалаар Монгол банкны зээлийн мэдээллийн санд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг оруулахтай холбогдуулан 06 дугаар сарын 14-ний өдөр 27 сумын төсөвт байгууллага болон ААН-ийн 350 гаруй дарга эрхлэгч, нягтлан бодогч нарт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн хүрээнд: Цусны донорын дэлхийн өдрийг зохион байгуулж, 100 хүндэт доноруудад хүндэтгэл үзүүлж, аймгийн телевизээр алдаршуулан, 1 Хүрэл донорт шагналыг гардуулан өгсөн. Мөн 6 хүндэт донорыг улсын чуулганд төлөөлөгчөөр томилон оролцуулж, 3 хүндэт донор шинээр нэмэгдсэн. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний чиглэлээр Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийг түшиглэн зүүн бүсийн 6 сумын эмч, эмнэлгийн мэргэжилтэнг оролцуулсан онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж, нийт 30 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг ажлын байранд чадавхижуулсан.

“Хүүхдийн амь тэнссэн үеийн яаралтай тусламж” сэдэвт сургалтыг ЭХЭМҮТөвийн үндэсний хэмжээний сургагч багштай хамтран зохион байгуулсан. Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төвийн нийт 65 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. ЭМГ-ын даргын А/26 дугаар тушаалаар Хэрэгцээт 200000 ОУН тунтай 12652ш, 987.246 төгрөгийн үнэ бүхий А амин дэмийг 27 суманд хуваарилан 2019 оны 6 сарын байдлаар хангалтын мэдээг авч нэгтгээд байна. Үүнд 6-11 сартай 1522 хүүхдэд, 12-59 сартай 7330 хүүхдэд, 1360 хөхүүл эхэд, нийт 10212 хүүхэд болон хөхүүл эхэд А аминдэмийг тараасан бөгөөд хангалт 80.7%-тай байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс улсын хэмжээнд зохион байгуулсан “Хүүхэд, өсвөр үеийхний сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, зөвлөгөө өгөх арга зүй” сэдэвт бүсчилсэн сургалтад 10 эмч мэргэжилтнүүд хамрагдаж, хүүхдийн сэтгэцийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

“Нийгмийн эрүүл мэндийн өдөр”-ийн үйл ажиллагааг 06 дугаар сард 4 удаа зохион байгуулснаас Зуунмод сумын хэмжээнд 6 багийн 47 иргэн, 587 ажилтан албан хаагчид, 26 сумын 358 ажилтан албан хаагчид болон иргэд, аймгийн хэмжээнд нийт 945 иргэд хамрагдсан. Үр дүн тооцох зорилгоор биеийн найрлага хэмжигч аппаратаар 50 хүнд үзлэг хийхэд 60,6% нь ус багатай, 67% нь уураг их, 88,2% нь холестерин их, 69,3% нь жингийн илүүдэлтэй гарсан байна.

Зооноз өвчин судлалын үндэсний төв, Нийслэлийн Зооноз өвчин судлалын төвтэй хамтран Сэргэлэн сум, Манзуширын хийдэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний байгалийн голомтын тандалт судалгааг 06 дугаар сарын 10-аас 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Үүнд хайгуулын 3314802243, 3314802242, 3314802244, 3314803513, 3314803511 секторуудын 45000 га талбайд, тандалт 3314801444, 3314802331, 3314802334, 3314802333 секторын 36000 га талбайд ажиллалаа. 2019 оны 06 дугаар сард халдварт өвчний /Энтеровирус-4, Хачигт халдвар, Дезинтерия-11, Сальмонеллэз-2, Салхинцэцэг-8/ 28 тохиолдолд ажилласан.

06 дугаар сарын 03-наас 06-ны өдрүүдэд Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 15-аас дээш насны сурагчид, сүрьеэгээр өвчилсөн иргэдийн хавьтлуудыг идэвхтэй илрүүлэг үзлэгт хамруулан, өвчнийг эрт илрүүлж, эмчилгээ, хяналтад бүрэн хамрууллаа. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2019 оны эхний 5 сарын байдлаар 370 эх төрж, 370 нярай мэндэлсэн. Нийт 67342 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 35770, амбулаторийн үзлэг 28967, идэвхитэй хяналтын үзлэг 2605 байна. Түргэн тусламжийн дуудлагаар 3166 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 64 буюу 2.02%, осол гэмтлийн дуудлага 37 буюу 1.17%-ийг эзэлж байна. 3152 өвчтөн 26838 ор хоног ашиглан хэвтэн эмчлүүлсэн ба дундаж ор хоног 8.5 байна.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

2019 оны эхний 5 дугаар сарын байдлаар аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөө 7692.2 сая төгрөг оруулахаас 7885.9 сая төгрөг оруулж, төсвийн орлогын төлөвлөгөө 193.6 сая төгрөг буюу 102.5 хувиар, сумдын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 140,8% буюу 558,4сая төгрөгөөр давж биелсэн байна. Сумдын төсвийн орлого давж биелэхэд үйл ажиллагааны орлого 112,0 сая төгрөг, хадгаламжийн хүүгийн орлого 106,5сая төгрөг, ҮХЭХ борлуулсны албан татвар 24,4сая төгрөг, Хог хаягдлын хураамжийн орлогоор 10,5сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр 6.4сая төгрөг, хүү торгуулийн орлого 62,5сая төгрөг, бусад орлого 34,6сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлжээ. Баян, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Зуунмод зэрэг сумд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулжээ. Аймгийн төвлөрсөн төсвийн орлогоос цалингийн ашгийн албан татвар, ҮХЭХ-ийн орлого, ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Алтанбулаг, Баян, Баянжаргалан, Заамар, Борнуур, Лүн, Сэргэлэн зэрэг 7 сум биелүүлээгүй байна.

Сумдад эхний 06 дугаар сарын 27-ны байдлаар өссөн дүнгээр нийт 36736579.4 мян төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон. Салбараа авч үзвэл боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 19843909.4 мян төгрөгийн санхүүжилтийг олгосон ба ерөнхий боловсролын сургуулиудад 13643249.3 мян, хүүхдийн цэцэрлэгт 6200660.1 мян, рүүл мэндийн сайдын багцаас 4252040.4 мян төгрөгийг олгосон ба сумдын эрүүл мэндийн төвд 4133492.0 мян, өрхийн эмнэлэгт 118548.4 мян төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 279986.6 мян, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 247581.6 мян төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна. Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 13981164.6 мян төгрөгийн санхүүжилт олгосон ба сумдын ИТХ, ЗДТГ, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 8133258.2 мян, орон

нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 3979803.2 мян, ОНХСангуудад 1598164.6 мян төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

2019 оны 5-р сарын гүйцэтгэлээр сумд болон төсөвт байгуулагууд нийт 118474,9 мян төгрөгийн авлага, 631034,6 мян төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 436611.7 мян төгрөг буюу 69.2% нь түлш, халаалтын зардлын өглөг, 69209.2 мян төгрөг буюу 10.9% нь цалингийн өглөг, 25390.0 мян төгрөг буюу 4.0% нь НДШимтгэлийн өр, 28419.6 мян төгрөг буюу 4.5% нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 27295,2 мян төгрөг буюу 4,33% нь эмийн зардлын өглөг, үлдсэн 44108,9 мян төгрөг буюу 7,1%-ийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн ИТХ, ИТХТэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилт, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт, урианы жилийн тайлан, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Төв аймгийн Засаг дарга болон сумдын Засаг дарга нарын хооронд, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний тайлан, сайдтай байгуулсан гэрээний тайлан, төсвийн шууд захирагч нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, “Хөгжлийн түүчээ-Төв аймаг 2024” аймгийн хөгжлийн хэтийн зорилтын тайланг 2017-2019 оны хагас жил хүртэлх өссөн дүнгийн гүйцэтгэлээр хэлтэс, агентлаг, харьяа байгууллагаас авч ХШҮ хийж байна.

Борнуур сумын ИТХТ-ийн 06 дугаар сарын 17-ны өдрийн 20 тоот албан бичгийн дагуу ИТХ, Борнуур сумын ЗДТГазрын 21 албан хаагчид ХШҮ-ний чиглэлээр сургалт зохион байгуулав.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

Дорнод аймагт зохион явуулсан Зүүн бүсийн аймгуудын сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтад 06 дугаар сарын 09-ний өдрөөс 12-ны өдрүүдэд хөтөлбөр төлөвлөгөөний дагуу 92.5 хувийн ирцтэйгээр оролцсон.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 249, 80 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 48 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны А/347 дугаар захирамж, 2019 оны Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн цэргийн анхан шатны сургалтыг 2019 оны 06 дугаар сарын 19-нөөс 14 хоногийн хугацаатай хээрийн байрлалд цэргийн дотоод албаны дүрмийн дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч 45 иргэнтэй сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу онол, дадлагын хичээлийг Зэвсэгт хүчний 016 дугаар бригадын мэргэжлийн офицер, ахлагч нартай хамтран зохион байгууллаа.